



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 1175

Улаанбаатар хот

“Татвар төлөгчдийн өдөр”-ийг  
тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.“Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтот жил”-ийн хүрээнд татвар төлөгчдийн өдрийг тохиолдуулан дүүргийн шилдэг татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийг алдаршуулах арга хэмжээ болон татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан албан хаагчдын дунд “Волейбол”-ын тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулахыг Татварын хэлтэс (Х.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

2.Тэмцээн зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тэмцээн зохион байгуулахад шаардлагатай 1,872,000 (Нэг сая найман зуун далан хоёр мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Мягмарсүрэн)-т, санхүүгийн тайланг 2024 оны 05 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Татварын хэлтэс (Х.Анхбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

AJIL/2024 он ажил/захирамж

1123200985

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 05 дугаар сарын 05 ны өдрийн  
А.А.А. дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



УДИРДАМЖ

2024 оны 05 дугаар сарын 02

Багахангай дүүрэг

“ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ӨДӨР”-ИЙГ УГТАН  
“ВОЛЕЙБОЛ”-ЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

НЭГ.ЗОРИЛГО

“Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтот жил”-ийн хүрээнд “Татвар төлөгчдийн өдөр”-ийг угтан дүүргийн татвар төлөгч байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажилтан албан хаагчдад татварын хуулийг сурталчлах, хөгжил дэвшлийг тодорхойлох,, хууль эрх зүйн орчныг дээшлүүлэхэд тэдний оролцоог нэмэгдүүлж, харилцаа хамтын ажиллагааг сайжруулах, хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд тэмцээний зорилго оршино.

ХОЁР.ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН

Тэмцээний техникийн зөвлөгөөнийг 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 14:00 цагт татварын хэлтсийн 201 тоот өрөөнд зохион байгуулна. Техникийн зөвлөгөөнөөр тэмцээн явагдах дүрмийг танилцуулна. Тэмцээнд оролцох багийн ахлагч мэдүүлэгтэйгээ цагтаа ирнэ. Эрхийн хураамж /40.000/ төгрөг авч ирэх Мэдүүлгийн загвар

Батлав

№	Овог нэр	Нас	Хүйс	Тоглогчийн үүрэг	Албан тушаал	Утасны дугаар
1						

ГУРАВ.ТЭМЦЭЭН ЯВАГДАХ ЖУРАМ

Тухайн байгууллага аж ахуйн нэгжүүдээс эрэгтэй 3, эмэгтэй 3, холимог баг бүрдүүлж тэмцээнд оролцоно. Багт сэлгээний эрэгтэй 1, эмэгтэй 1 тамирчин байна. Багийн бүрэлдэхүүнд 35-аас дээш настай 1, 45-аас дээш настай 1 тамирчин заавал талбайд гарч тоглоно. 3 дамжуулалтын 1 бөмбөгийг заавал эмэгтэй тамирчин авна.

## ДӨРӨВ.ТЭМЦЭЭН ЯВАГДАХ ХУГАЦАА

Тэмцээн 2024 оны 05 дугаар 08-ны өдөр Биеийн тамир спортын хороонд 09:00 цагт явагдана.

### ТАВ.ТЭМЦЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- ✓ ААНБ-ууд зөвхөн өөрийн байгууллагын ажилтнаар баг бүрдүүлж оролцоно.
- ✓ Гадны пүүзээ сольж талбай дээр гарах
- ✓ Шүүгчидтэй маргалдахыг хатуу хориглоно.
- ✓ Тэмцээнд эрэгтэй, эмэгтэй холимог баг тамирчид оролцоно
- ✓ 5 минут хүлээгээд ирэхгүй багийн хожлыг эсрэг багт өгнө.
- ✓ Багийн мэдүүлэгт ороогүй тамирчин тоглохгүй.
- ✓ Техникийн зөвлөгөөнд оролцоогүй багаа бүртгүүлээгүй багийг тэмцээнд оролцуулахгүй.

### ЗУРГАА. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Тэргүүн байр – Шилжин явах цом, Алтан медаль, Өргөмжлөл, Мөнгөн шагнал

Дэд байр -Мөнгөн медаль, Өргөмжлөл, Мөнгөн шагнал

Гутгаар байр -Хүрэл медаль, Өргөмжлөл, Мөнгөн шагнал

ХОЛБОО БАРИХ ДУГААР: 88035793

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:  
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны... дугаар сарын...ны өдрийн  
... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

“ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ӨДӨР”-ИЙГ УГТАН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
“ВОЛЕЙБОЛ”-ЫН ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг Бүрийн үнэ	Нийт үнэ
1.	1-р байр	ш	1	400.000	400.000
2.	2-р байр	ш	1	350.000	350.000
3.	3-р байр	ш	1	300.000	300.000
4.	1-р байр Алтан медаль	ш	8	13,000	104.000
5.	2-р байр Мөнгөн медаль	ш	8	13,000	104.000
6.	3-р байр Хүрэл медаль	ш	8	13,000	104.000
7.	Өргөмжлөл	ш	3	20,000	60.,000
8.	Шилжин явах цом	ш	1	150.000	150.000
9.	Шилдэг татвар төлөгчдөд олгох өргөмжлөл	ш	3	100.000	300.000
<b>Нийт зардал</b>					<b>1.872.000</b>